



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/268

Арвайхээр

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргад хандаж тусламж хүсэж өргөдөл ирүүлсэн хүнд өвчтэй, өрхийн орлогогүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэр бүхий 6 иргэнд нийт 2,900,000 (хоёр сая есөн зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх 2,900,000 (хоёр сая есөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100578

Аймгийн Засаг даргын 2021 оны 06
дугаар сарын 04-ны өдрийн 17268 дүгээр
захирамжийн хавсралт



НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ
ИРГЭДИЙН НЭРС

№	Овог, нэр	Оршин суугаа хаяг	Мөнгөн дүн
1.	Э.Энхжаргал	Арвайхээр сумын 12 дугаар баг	1000000
2.	Н.Гэрэлмаа	Хайрхандулаан сумын 2 дугаар баг	500000
3.	П.Баясгалан	Арвайхээр сумын 12 дугаар баг 42-15	500000
4.	С.Саранцэцэг	Хархорин сумын 1 дүгээр баг 15-7	300000
5.	Г.Гончиг	Хужирт сумын 5 дугаар баг	300000
6.	Б.Цэрэндаш	Зүүнбаян-Улаан сумын 4 дүгээр баг	300000
Нийт дүн			2900000

--oOo --